

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар
сарын ...-ний өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү хөдөлмөрийн гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г "....." ХХК /цаашид "компани" гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал....., нөгөө талаас.....-тоот регистрийн дугаартай Монгол Улсын иргэн.....нар /цаашид, "Ажилтан" гэх /Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай хууль"-ийг үндэслэн харилцан тохиролцож /хамтад нь Талууд гэнэ /, дараах нөхцөлөөр байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

- 1.1. Энэхүү гэрээ нь Ажил олгогч болон Ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулах зорилготой.
- 1.2. Ажилтан нь энэхүү гэрээнд заасан ажлыг гэрээнд заасан болзол, нөхцөл, тохиролцсон хөлсөөр гүйцэтгэх, Ажил олгогч нь гэрээгээр тохиролцсон хөлс олгох нь энэ гэрээний гол зүйл мөн.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

- 2.1. **Албан тушаал:**.....
- 2.2. **Ажил үүрэг:**
- 2.3. **Хөдөлмөрийн нөхцөл:**
- 2.4. Ажил олгогч нь ажилтныг гэрээнд заасан албан тушаалд ажиллуулах, ажилтан нь энэ гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээнэ. Ажлын байрны тодорхойлолт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 2.5. Ажилтан Гүйцэтгэх захирал болон газар нэгжийн удирдлагын өмнө ажлаа хариуцан тайлагнана.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1. Компаний хөдөлмөрийн дотоод журам, компаний үйлжиллагааны онцлог, ажилтны хүсэл сонирхлыг харгалзан талууд хөдөлмөрийн гэрээг **2016 оны ... дүгээр сарын...-ний өдрөөс эхлэн 201.. оны .. дугаар сарын...-ний өдрийг хүртэл..... хугацаанд туршилтын хугацаатайгаар байгуулав.**
- 3.2. Гэрээний хугацаа дуусмагц ажил олгогч ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүн, бүтээмж, гэрээний хугацаанд ямар нэгэн ноцтой зөрчил гаргасан эсэхийг харгалзан уг гэрээг шинэчлэн байгуулна.

ДӨРӨВ. ЦАЛИН ХӨЛС, ТУСЛАМЖ, НӨХӨН ОЛГОВОР, ТЭТГЭМЖ

- 4.1. Ажилтны сарын үндсэн цалин туршилтын хугацаанд:/ төгрөг байна.
- 4.2. Ажилтны сарын үндсэн цалин компанийн ажилтнуудын албан тушаалын ангилалд тулгуурлан батлагдсан цалингийн зэрэглэлийн дагуу тогтоогдоно.
- 4.3. Цалин хөлсийг сар бүрийн-ны өдөр болон сүүлийн хагасын-ны ажлын өдөр хоёр хуваан олгоно. Энэ өдөр нь баярын эсхүл амралтын өдөр тохиовол тухайн өдрийн өмнөх ажлын өдөр олгоно.
- 4.4. Цалин олгохдоо хуулийн дагуу ногдох татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаж олгоно.
- 4.5. Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ тус компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар албан тушаал хавсрах буюу түр хугацаагаар эзгүй байгаа ажилтны үүргийг орлон ажилласан бол орлон гүйцэтгэсэн ажлын үндсэн цалингаас нь "Хөдөлмөрийн дотоод журам" -д заасан хувь хэмжээгээр тооцон нэмэгдэл хөлс олгоно.

/Үргэлжлэл бий /